



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/127/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:<a href="mailto:tsetsegsurena@audit.gov.mn">tsetsegsurena@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Бадрал Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:badralts@audit.gov.mn">badralts@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>11</b>
3.1 Төлбөрийн акт .....	11
3.2 Зөвлөмж.....	12
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>13</b>
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	13

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс:(976)-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

АХБ.ОА.25 № 174  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.ДӨМӨГТҮШИГ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулсан, тайлант онд төсөв хасах тодотгол хийсэнтэй холбоотой байгууллагад тайлант онд 27,169.5 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Буянт сумын Засаг даргын Тамгын газарт 2025 онд хөрөнгөөр оруулалтаар нийт 718,936.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүйгээр бүртгэснээс, Ачаа жинлэх пүү, татмын ойжуулалтын хашаа, булгийн хашаа, ногоон байгууламж бүхий орчны тохижилт зэрэг ажлуудыг орон нутгийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс хийлгэн хүлээн авсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

8428070409

Аудитыг гүйцэтгэхэд материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр, тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 10 зорилтын хүрээнд 85 арга хэмжээг төлөвлөн сумын Засаг дарга 85.6 хувиар дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>89,705,631.54</u></b>	<b><u>124,932,925.26</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	20,837,231.54	37,788,525.26
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	500,797.54	500,797.54
33300	Татаас, санхүүжилтийн авлага	20,336,434.00	36,193,927.72
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	1,093,800.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	1,093,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	65,268,400.00	78,321,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,933,400.00	44,986,400.00
35410	Бичиг хэргийн материал	1,083,400.00	1,568,400.00
35420	Аж ахуйн материал	29,461,000.00	42,029,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,389,000.00	1,389,000.00
35600	Мал амьтад	33,335,000.00	33,335,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	3,600,000.00	8,823,000.00
36300	Тэжээлийн нөөц	3,600,000.00	8,823,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,726,470,354.08</u></b>	<b><u>5,010,137,484.39</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,726,470,354.08	5,010,137,484.39
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,380,124,954.08	4,663,792,084.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,059,754,444.64	3,140,912,986.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(937,982,273.77)	(1,173,812,866.23)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	427,599,950.00	454,876,750.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,168,283.27)	(116,179,250.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	278,803,233.00	305,155,094.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,261,893.56)	(134,013,294.72)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,028,122.00	86,143,122.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,358,119.68)	(43,790,268.27)
39209	Зам, гүүрний байгууламж	426,328,091.00	426,328,091.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(80,190,057.76)	(101,075,800.88)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	12,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,226,623,769.00	1,881,191,092.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,210,569.52)	(73,943,572.21)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	93,158,542.00	-
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	346,345,400.00	346,345,400.00
39301	Программ хангамж	3,117,000.00	3,117,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,117,000.00)	(3,117,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	346,345,400.00	346,345,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,816,175,985.62</u></b>	<b><u>5,135,070,409.65</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>400,000.00</u></b>	<b><u>27,169,522.60</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	400,000.00	27,169,522.60
<b>413</b>	<b>Өглөг</b>	400,000.00	27,169,522.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	192,020.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	12,026,802.60
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	400,000.00	14,950,700.00

41361	Байгууллагад төлөх өглөг	400,000.00	11,884,600.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	3,066,100.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>4,815,775,985.62</u></b>	<b><u>5,107,900,887.05</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,815,775,985.62	5,107,900,887.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	776,113,300.00	776,113,300.00
51101	Өмч: - төрийн	776,113,300.00	776,113,300.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	3,737,455,896.03	4,029,580,797.46
51210	Өмнөх үеийн үр дүн	3,737,455,896.03	3,746,666,465.55
51220	Тайлант үеийн үр дүн	-	282,914,331.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	302,206,789.59	302,206,789.59
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>4,816,175,985.62</u></b>	<b><u>5,135,070,409.65</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,747,633,766.00</b>	<b>1,761,668,923.58</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,699,693,784.00</b>	<b>723,221,766.33</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,699,693,784.00	<b>723,221,766.33</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,635,298.00</b>	<b>723,221,766.33</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,635,298.00	4,057,131.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	1,629,501,386.00	694,439,785.33
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	67,557,100.00	24,724,850.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,050,575,280.00</b>	<b>1,038,447,157.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	160,882,082.00	48,604,457.25
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,882,082.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,834,943.25
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	45,769,514.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	887,057,900.00	989,842,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	887,057,900.00	989,842,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,335,331,622.39</b>	<b>1,478,754,591.67</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,335,331,622.39</b>	<b>1,478,754,591.67</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,304,222,539.22	1,458,300,779.16
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	637,767,271.25	754,456,305.12
210101	Үндсэн цалин	366,008,893.06	366,143,239.04
210102	Нэмэгдэл	188,969,928.22	262,288,787.05
210104	Урамшуулал	49,621,333.62	40,346,870.68
210105	Гэрээт ажлын хөлс	33,167,116.35	85,677,408.35
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	78,055,043.58	95,605,533.43
210201	Тэтгэврийн даатгал	52,526,643.58	63,407,287.20
210202	Тэтгэмжийн даатгал	6,382,100.00	7,909,878.62

Буянт сумын сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,191,000.00	5,404,959.47
210204	Ажилгүйдлийн даатгал	3,191,000.00	4,202,420.56
210205	Эрүүл мэндийн даатгал	12,764,300.00	14,680,987.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,760,400.00</b>	<b>68,100,140.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,739,071.56	13,882,262.92
210302	Түлш, халаалт	31,021,328.44	54,217,878.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,819,300.00</b>	<b>36,291,991.90</b>
210401	Бичиг хэрэг	6,454,400.00	5,938,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,612,700.00	24,305,091.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,204,800.00	2,929,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	559,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,547,400.00	2,560,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>553,700.00</b>	<b>114,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	114,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,773,700.00</b>	<b>2,154,850.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	90,000.00
210604	Урсгал засвар	2,456,700.00	2,064,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,914,000.00</b>	<b>7,867,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,914,000.00	7,867,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,189,600.00</b>	<b>21,576,102.25</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,069,800.00	20,571,169.25
210803	Даатгалын үйлчилгээ	519,000.00	266,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	273,300.00	113,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	102,000.00	50,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,000.00	180,000.00
210807	Газрын төлбөр	307,500.00	394,852.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>487,389,524.39</b>	<b>472,133,755.54</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	176,331,695.00	47,776,131.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	309,573,829.39	424,357,624.54
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,109,083.17</b>	<b>20,453,812.51</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,796,596.00</b>	<b>16,447,825.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,347,825.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,096,596.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,172,487.17</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,172,487.17	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>140,000.00</b>	<b>4,005,987.51</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	140,000.00	4,005,987.51
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>1,412,302,143.61</u></b>	<b><u>282,914,331.91</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>1,412,302,143.61</u></b>	<b><u>282,914,331.91</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,050,575,280.00</u></b>	<b><u>1,066,994,922.25</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,635,298.00</b>	<b>4,057,131.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,635,298.00	4,057,131.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,635,298.00	4,057,131.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,635,298.00	4,057,131.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,047,939,982.00</b>	<b>1,062,937,791.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	160,882,082.00	73,095,091.25
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,882,082.00	1,117,440.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,834,943.25
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	69,142,708.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	887,057,900.00	989,842,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	887,057,900.00	989,842,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,050,575,280.00</u></b>	<b><u>1,066,994,922.25</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>1,050,575,280.00</u></b>	<b><u>1,066,994,922.25</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>999,269,762.83</b>	<b>1,010,347,182.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>637,767,271.25</b>	<b>757,403,422.85</b>
210101	Үндсэн цалин	366,008,893.06	369,559,882.76
210102	Нэмэгдэл	188,969,928.22	262,288,787.05
210104	Урамшуулал	49,621,333.62	40,346,870.68
210105	Гэрээт ажлын хөлс	33,167,116.35	85,207,882.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,055,043.58</b>	<b>92,466,395.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,526,643.58	62,853,372.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,382,100.00	7,587,330.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,191,000.00	3,833,253.10
210204	Ажилгүйдлийн даатгал	3,191,000.00	3,585,269.29
210205	Эрүүл мэндийн даатгал	12,764,300.00	14,607,170.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>44,760,400.00</b>	<b>57,700,380.22</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,739,071.56	15,256,880.22
210302	Түлш, халаалт	31,021,328.44	42,443,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,571,900.00</b>	<b>25,826,200.00</b>
210401	Бичиг хэрэг	6,254,400.00	3,758,800.00
210402	Тээвэр, шатахуун	13,112,700.00	19,158,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,204,800.00	2,909,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>553,700.00</b>	<b>204,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	204,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,773,700.00</b>	<b>2,447,750.00</b>

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	290,900.00
210604	Урсгал засвар	2,456,700.00	2,156,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,914,000.00</b>	<b>7,867,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	6,914,000.00	7,867,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,129,600.00</b>	<b>21,115,402.25</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,009,800.00	15,301,569.25
210803	Даатгалын үйлчилгээ	519,000.00	266,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	273,300.00	113,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	102,000.00	50,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	918,000.00	4,988,900.00
210807	Газрын төлбөр	307,500.00	394,852.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>176,744,148.00</b>	<b>45,315,531.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,260,148.00	45,315,531.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,305,517.17</b>	<b>56,647,740.23</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,796,596.00</b>	<b>16,447,825.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16,347,825.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,096,596.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,700,000.00	100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,172,487.17</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,172,487.17	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>20,336,434.00</b>	<b>40,199,915.23</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,336,434.00	40,199,915.23
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	776,113,300.00	302,206,789.59	3,737,455,896.03	4,815,775,985.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	776,113,300.00	302,206,789.59	3,737,455,896.03	4,815,775,985.62
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	776,113,300.00	302,206,789.59	3,737,455,896.03	4,815,775,985.62
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	776,113,300.00	302,206,789.59	3,737,455,896.03	4,815,775,985.62

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,210,569.52	9,210,569.52
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>302,206,789.59</b>	<b>3,746,666,465.55</b>	<b>4,824,986,555.14</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	282,914,331.91	282,914,331.91
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>776,113,300.00</b>	<b>302,206,789.59</b>	<b>4,029,580,797.46</b>	<b>5,107,900,887.05</b>

## 2.5 Аудит хийсэн төвсийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,129,035,800.00</b>	<b>989,893,843.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,105,453,800.00</b>	<b>973,446,018.49</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>850,976,900.00</b>	<b>757,403,422.85</b>
210101	Үндсэн цалин	400,126,600.00	369,559,882.76
210102	Нэмэгдэл	278,308,600.00	262,288,787.05
210104	Урамшуулал	40,346,900.00	40,346,870.68
210105	Гэрээт ажлын хөлс	132,194,800.00	85,207,882.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>106,372,100.00</b>	<b>92,466,395.70</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,333,100.00	62,853,372.14
210202	Тэтгэмжийн даатгал	8,509,700.00	7,587,330.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,254,900.00	3,833,253.10
210204	Ажилгүйдлийн даатгал	4,254,900.00	3,585,269.29
210205	Эрүүл мэндийн даатгал	17,019,500.00	14,607,170.55
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>60,342,300.00</b>	<b>54,764,016.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,098,800.00	12,320,516.94
210302	Түлш, халаалт	42,443,500.00	42,443,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,243,600.00</b>	<b>17,538,600.00</b>
210401	Бичиг хэрэг	5,457,900.00	3,758,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,074,800.00	10,870,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,710,900.00	2,909,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>683,200.00</b>	<b>204,800.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	683,200.00	204,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,110,200.00</b>	<b>2,447,750.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	494,600.00	290,900.00
210604	Урсгал засвар	2,615,600.00	2,156,850.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>8,383,700.00</b>	<b>7,867,300.00</b>
210702	Дотоод албан томилот	8,383,700.00	7,867,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,662,500.00</b>	<b>19,361,433.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,588,400.00	13,547,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	519,000.00	266,325.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	113,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	102,000.00	50,200.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,397,800.00	4,988,900.00
210807	Газрын төлбөр	830,300.00	394,852.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,679,300.00</b>	<b>21,392,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,679,300.00	21,392,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,582,000.00</b>	<b>16,447,825.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>23,582,000.00</b>	<b>16,447,825.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,348,400.00	16,347,825.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,233,600.00	100,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,129,035,800.00</b>	<b>989,893,843.49</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,128,430,800.00</b>	<b>985,836,712.49</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,128,430,800.00	985,836,712.49
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000.00	4,057,131.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	4,057,131.00
<b>4.00</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>5.00</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>228,484,875.00</b>	<b>73,095,091.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>228,484,875.00</b>	<b>73,095,091.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>208,148,441.00</b>	<b>36,901,163.53</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	-	<b>2,936,363.28</b>
210301	Гэрэл, цахилгаан	-	2,936,363.28
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	500,000.00	<b>8,287,600.00</b>
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	8,287,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,940,000.00</b>	<b>1,753,969.25</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,940,000.00	1,753,969.25
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>199,708,441.00</b>	<b>23,923,231.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	199,708,441.00	23,923,231.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,336,434.00</b>	<b>36,193,927.72</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>20,336,434.00</b>	<b>36,193,927.72</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	20,336,434.00	36,193,927.72
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>228,484,875.00</b>	<b>73,095,091.25</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>228,484,875.00</b>	<b>73,095,091.25</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,431,544.00	1,117,440.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	160,882,082.00	2,834,943.25
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	55,171,249.00	69,142,708.00

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 86,191.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 72,670.4 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийг зөрүүтэй тайлагнасан.-42,212.5 мянган төгрөг,
- Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн-30,457.9 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 13,521.2 мянган төгрөгийн зөрчлөөс зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,521.2 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,105.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 11,415.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.1 Төлбөрийн акт

##### 3.1.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 оны 2 дугаар сард архив бичиг хэргийн ажилтанд хаагчид цалин хөлсний нэмэгдэлд илүү тооцон 513,200 төгрөг, 7, 8 дугаар саруудад 2 албан хаагчид ээлжийн амралттай байх хугацаанд цалин хөлсийг давхардуулан 1,592,445 төгрөг, нийт 2,105,645 төгрөгийг илүү тооцон олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1-д “Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

<sup>1</sup> Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна

## 3.2 Зөвлөмж

### 3.2.1 Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 оны 2 дугаар сард өмнөх оны үр дүнгийн урамшуулал олгосон бөгөөд өнгөрсөн онд өглөгөөр тусгаагүй, 2021 оноос өмнө аймгийн ЗДТГ-аас хүлээн авсан өвс тэжээлийн тооцоо нийлж өглөг баталгаажуулаагүй, тайлагнаагүйтэй холбоотой 11,415,592 төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ”, 16 дугаар зүйлийн 16.5.7-т “Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, 14.4.3-д “бүх өр төлбөр”-ийг заавал тусгана, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант оны өр төлбөрийг санхүүгийн жилээр тооцон үнэн зөв бүртгэн, тайлагнах, үүссэн өглөг авлагын тооцоог баталгаажуулан барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд үр дүнг зөрүүтэй тооцон илэрхийлсэн	1	30,457.9			1	30,457.9	1	30,457.9	-	-
Санхүүгийн байдлын тайланд бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийг зөрүүтэй тайлагнасан.	1	42,212.5			1	42,212.5	1	42,212.5		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>72,670.4</b>			<b>2</b>	<b>72,670.4</b>	<b>2</b>	<b>72,670.4</b>		

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 оны 2 дугаар сард архив бичиг хэргийн ажилтанд хаагчид цалин хөлсний нэмэгдэлд илүү тооцон 513,200 төгрөг, 7, 8 дугаар саруудад 2 албан хаагчид ээлжийн амралттай байх хугацаанд цалин хөлсийг давхардуулан 1,592,445 төгрөгийг илүү тооцон олгосон	1	2,105.6	1	2,105.6				
2025 оны 2 дугаар сард өмнөх оны үр дүнгийн урамшуулал олгосон бөгөөд өнгөрсөн онд өглөгөөр тусгаагүй, 2021 оноос өмнө аймгийн ЗДТГ-аас хүлээн авсан өвс тэжээлийн тооцоо нийлж өглөг баталгаажуулаагүй, тайлагнаагүй	1	11,415.6					1	11,415.6
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>13,521.2</b>	<b>1</b>	<b>2,105.6</b>			<b>1</b>	<b>11,415.6</b>

#### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			